



**ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ  
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ**

17042 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо,  
Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний  
ерөнхий газар 4 давхар. Утас/Факс: (976) 7012 4949,  
И-мэйл: info@habemt.gov.mn, Вэбсайт: www.habemt.gov.mn

2021.02.23 № 78  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
ЭРҮҮЛ АХУЙН САЛБАР ХОРООНД**

Уралдаан зохион байгуулж,  
шалгаруулалтын дүнг ирүүлэх тухай

Үйлдвэрлэлийн орчин, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулж, ажилтныг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, бусад эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр аж ахуйн нэгж байгууллагаас явуулж буй үйл ажиллагаа, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” уралдааныг жил бүр зохион байгуулдаг.


“Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага-2020” уралдааныг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 02 сарын 14-ний өдрийн А/64 тоот тушаал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооноос баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2021 оны төлөвлөгөө”-ний хүрээнд 10 дахь жилдээ зохион байгуулах гэж байна.

Иймд “Эрүүл, аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага шалгаруулах журам”-ын дагуу нэгдүгээр шатны шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан байгууллагын материал, шалгаруулалтын дүнг 2021 оны 03 сарын 10-ний дотор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд ирүүлнэ үү.

Жич:

Дэлгэрэнгүй мэдээллийг 99850240, 88023900 дугаарын утаснаас авна уу.

ЗАХИРАЛ



М.ДАВААБАТ